



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/52

Шивээговь сум

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.6, 9 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн “Гоц халдварт шүлхийгээс сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах тухай” А/113 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, вакцинжуулалтын ажлын хяналт хийх ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 10 хоногт багтаан зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | |
|-----------------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | С.Отгонбаатар
(2 дугаар багийн Засаг дарга) |
| Гишүүд: | Д.Отгонбаатар
(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн) |
| | Т.Өлзийбуд
(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн) |

3. Дээрх ажилд зарцуулагдах 500,000 (таван зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн "Малын тоо толгойд ногдох албан татварын зардал"-аас гаргахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

4. Үйл ажиллагааг чанартай гүйцэтгэж, тухай бүрт тайлагнахж байхыг ажлын хэсгийн дарга (С.Отгонбаатар)-т, Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ

